



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/27

Баян-Адарга сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам 2.1.5, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх зорилгоор зорилтот бүлгийн иргэдийг элэгний В, С вирус, хеликобактер илрүүлэх оношилгооны тест худалдан авах зардалд 1500000 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Агиймаа)-д зөвшөөрсүгэй.

3.Зорилтот бүлгийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулж ажиллахыг эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ж.Батсүрэн)-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Бат-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.Л.ХАГВАДОРЖ